



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 0/34

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6.а, Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолоор батлагдсан "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах аймгийн комисст шилжүүлсэн байгалийн өнгөт чулууг дуудлага худалдаагаар худалдан борлуулж улсын орлого болгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

-Аймгийн мэргэжлийн хяналтын газрын дарга

Гишүүд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Хоёр. Дуудлага худалдааг холбогдох журмын дагуу зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Сүнгээ/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 257